



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 21 өдөр

Дугаар А/154

Бат-Өлзий сум

Гэрээ байгуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх малын чанар сайжруулахад зориулагдсан малыг ялган ангилах тоног төхөөрөмжийг худалдан авах ажлыг Эко надмид хязгаарлагдмал хариуцлагатай компантай шууд худалдан авах аргаар гэрээ байгуулсугай.

2. Эко надмид хязгаарлагдмал хариуцлагатай компантай гэрээ байгуулж шууд худалдан авах үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг орлогч дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

3. Малын чанар сайжруулахад зориулагдсан малыг ялган ангилах тоног төхөөрөмжийг худалдан авах 4950,000 (дөрвөн сая есөн зуун тавин мянган) төгрөгийн санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН



627301315